



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/467

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт, "Алсын хараа-2050" Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын 2.1.11 дэх зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9 дэх зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж, ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар, Тэгш хамран сургах боловсролын хэлтэст, төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж, явц хэрэгжилтийг 14 хоног тутам тайлагнаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Н.Нарангэрэл/- т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 1882

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 11 дугаар сарын 21-ны  
өдрийн 44.67 тушаалын хавсралт

БОЛОВСРОЛЫН БОЛОН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ЦЭЦЭРЛЭГ,  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ/

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах	Хамтран хэрэгжүүлэх
<b>Нэг. Тусгай сургуулиудын удирдлага, зохион байгуулалт, сургуулийн менежментийг сайжруулах хүрээнд</b>				
1.	Нийслэлийн ерөнхий боловсролын 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургуулиудад үйл ажиллагааны зураглал хийж, дүгнэлт гарган, сургуулиудын бүтэц, орон тооны жишиг нормативыг боловсруулж, танилцуулах	XI/01-XII/20	НБГ БСҮХ	БЕГ ТХСБХ ТББ
2.	Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185-р тогтоолоор батлагдсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	XI/25- XII/25	БНБТГ ЕББУЗГ СХОГ ТХСБХ	БЕГ БСҮХ Сургуулиуд
3.	2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 307/91/237 дугаар тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох" журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	XI/15-XII/25	БНБТГ ЕББУЗГ ТХСБХ СХОГ	БЕГ БСҮХ Сургуулиуд
4.	Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 63 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, чадамжийн гэрчилгээтэй төгсгөх асуудлыг судалж, холбогдох мэргэжлийн боловсролын сургуулиудтай хамран ажиллах зохицуулалтын санал танилцуулах	XI/01-XII/30	МБТБГ ТХСБХ	БЕГ 63, 55-р сургууль
5.	Нийслэлийн ерөнхий боловсролын 63, 55 дугаар сургуулийн сургалтын менежерийг 70, 29 дүгээр сургуульд сэлгэн ажиллуулах	XI/01-III/01	НБГ	63, 55, 70, 29-р сургууль
6.	Нийслэлийн ерөнхий боловсролын 63, 55 дугаар сургуулийн захирлыг 70, 29 дүгээр сургуульд зөвлөхөөр ажиллуулах зохицуулалт хийж, шийдвэрлэх	XI/01-III/01	НБГ	63, 55, 70, 29-р сургууль
7.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулах - Зөвлөгөөн зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж, ажиллах	XI/01-XII/01	БЕГ НБГ БНБТГ ЕББУЗГ ТХСБХ	БСҮХ БУТ

8.	Танхимын сургалтад тогтмол хамрагдахгүй байгаа 2-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэг бүрээр нэгтгэн гаргах, боловсролд хамруулах хувилбарыг боловсруулж, танилцуулах	ХИ/01- XI/30	БСҮХ БЕГ ТХСБХ	НБГ БШУГ
<b>Хоёр. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд:</b>				
9.	Нийслэлийн ерөнхий боловсролын 25, 63 дугаар сургуулийн өргөтгөл барих төсвийг судлан, шийдвэрлэх санал танилцуулах	ХИ/01- XI/30	СХОГ БЕГ НБГ	
10.	Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургуулийн газрын асуудлыг шийдвэрлэж, 116 дугаар сургуулийн дотуур байрын зураг төсвийг боловсруулах асуудлыг шийдвэрлэх	ХИ/01- XI/30	БЕГ НБГ	СХОГ ТХСБХ
11.	Нийслэлийн ерөнхий боловсролын 55, 116, 29 дүгээр сургуулийн лифт барих төсөв тооцооллыг боловсруулж, төслүүдэд хүсэлт хүргүүлэх	ХИ/01-ХИ/20	СХОГ ТХСБХ	БЕГ НБГ
12.	Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 70 дугаар сургуулийн дээврийн засварын ажлын төсвийг шийдвэрлэх	ХИ/01-ХИ/20	СХОГ	БЕГ НБГ
13.	БЗД-т байрлах ШУ-ны хүрээлэнгүүдийн байрнаас 55 дугаар сургуулийн хичээлийн байрны асуудлыг шийдвэрлэх	ХИ/01- XI/30	СХОГ ШУГ БЕГ	ТХСБХ НБГ 55-р сургууль
14.	Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 70-р сургуулийн суралцагчийн сандал, ширээний техникийн тодорхойлолтыг тусад нь баталж, худалдан авалтыг зохион байгуулах	ХИ/01- XII/30	СХОГ БЕГ ТХСБХ	БЕГ НБГ
15.	Брайль цаас худалдан авах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах, 116 дугаар сургуулийн дотоод нөөцөөр брайль сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн хэвлэж, бүх шатны сургалтын байгууллагад суралцаж буй харааны бэрхшээлтэй суралцагчдыг сурах бичиг, хэрэглэгдэхүүнээр хангах асуудлыг судлан, санал танилцуулах	ХИ/01-ХИ/30	БЕГ БСҮХ НБГ	ТХСБХ 116-р сургууль
16.	Нийслэлийн ерөнхий боловсролын 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгийн багш нарыг зөөврийн компьютерээр хангах, сургуулийн орчин дахь интернетийн хурдыг нэмэгдүүлэх ажлыг шийдвэрлэх	ХИ/01-ХИ/20	ЦБСМГ БЕГ	Сургуулиуд
17.	Нийслэлийн ерөнхий боловсролын 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургуулиудыг ухаалаг самбараар хангах	ХИ/01-ХИ/20	ЦБСМГ БЕГ	СХОГ
<b>Гурав. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сайжруулах хүрээнд:</b>				
18.	Суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээнд дүн үнэлгээг тооцох, чадамжийн гэрчилгээ олгох загвар боловсруулах, санал танилцуулах	ХИ/01-ХИ/20	БЕГ БҮТ ТХСБХ	НБГ
19.	Тусгай хэрэгцээт суралцагчид элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тохируулга хийх, хөнгөлөлт нөхцөлийг журамд нэмэлтээр тусгах санал боловсруулах	жилдээ	БЕГ БҮТ	Сургуулиуд

					БСҮХ	
20.	Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийх сорил боловсруулах			жилдээ	БЕГ БҮТ	БСҮХ
21.	Дохионы хэлний хос хэлний арга зүй, модулийг боловсруулах			жилдээ	БЕГ БСҮХ	ТХСБХ
22.	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний датаг боловсронгуй болгох, тусгай сургуулийн багш нарын үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулах			XI/01-XII/30	БНБТГ БҮТ БЕГ ТХСБХ	Сургуулиуд
<b>Дөрөв. Хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах хүрээнд</b>						
23.	Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн багш нарыг гадаад улсад бэлтгэх асуудлыг судалж, санал танилцуулах			XI/30-XII/30	ГХХАГ ТХСБХ	
24.	Хөдөлмөр засалчаар 2 дахь бакалаврт суралцаж байгаа 13 оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх			X/01 - XI/30	СХОГ ДБУЗГ БЗС	ТХСБХ АШУУИС
25.	Судлагдахууны багш нарыг тусгай хэрэгцээт боловсрол, брайль, дохионы хэлээр мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах			Жилдээ	БЕГ МУБИС ТХСБХ	ТББ
26.	Турк улсад туршлага судлах ажлыг зохион байгуулах /240 багш, ажилтан/			Жилдээ	ГХХАГ СХОГ БЕГ ТХСБХ	63, 55-р сургууль
<b>Тав. Суралцагчийн хоол үйлдвэрлэл, хүнсний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах хүрээнд</b>						
27.	1 хүүхдэд ногдох үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх асуудлыг судлах, хоолны чанар, шим тэжээлийг сайжруулах			XI/01-XIII/20	СХОГ СХҮҮХ БЕГ	
28.	Сургуулиудын хоол үйлдвэрлэлийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах			XII сард	БЕГ СХҮҮХ	ОУБ
29.	Нийслэлийн ерөнхий боловсролын 116, 29 дүгээр сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдын Үдийн хоолны мөнгийг бүрэн олгох асуудлыг шийдвэрлэх			XII сард	СХОГ СХҮҮХ	
30.	Дотуур байранд хоол хүнс хадгалах хөргөгчөөр хангах			XII сард	БЕГ	ОУБ
<b>Зургаа. Суралцагчийн хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд</b>						
31.	Нийслэлийн ерөнхий боловсролын 116, 29 дүгээр сургуулийн дотуур байран дахь интернетийн хурдыг сайжруулах, сурагчдыг бие даан суралцах техник, тоног төхөөрөмжөөр хангах			жилдээ	БЕГ НБГ ЦБСМГ	116, 29-р сургууль
32.	Гадаад улсад суралцахаар шалгалтанд бэлтгэж буй суралцагчдад дэмжлэг үзүүлэх			жилдээ	ГХХАГ ТХСБХ	БЕГ БЗС

33.	Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн дотуур байрын сурагчдын хөгжлийн өрөөг тохижуулах, насны онцлогт тохирсон тоглоом, хэрэглэгдүүнээр хангах	жилдээ	БЕГ НБГ	ТХСБХ 29-р сургууль
34.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийг бүрэн оношлох ажлыг зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох	жилдээ	БНБТГ ТХСБХ	ОУБ
35.	Medlee цахим сургуульд хэл засал, дохионы хэлний цахим хичээл оруулах ажлыг судлан шийдвэрлэх	XI/01-XII/20	БНБТГ ТХСБХ	Medlee цахим сургууль
36.	Сургуулиудын автобусны шатахууны зардлыг нэмэгдүүлж, автобусыг бүрэн ашиглах асуудлыг шийдвэрлэх	XI/01-XII/30	СХОГ БЕГ	НБГ
37.	Тусгай хэрэгцээт хүүхдийн зориулалтаар тоноглогдсон автобусны үнийн судалгаа хийх, санал танилцуулах	XI/01-XII/20	БЕГ	НБГ Сургуулиуд
38.	Сувиллын цэцэрлэг ажиллуулах зуслангийн газрын асуудлыг судлан, санал танилцуулах	жилдээ	СХОГ ТХСБХ СӨБХ	БЕГ НБГ Цэцэрлэгүүд
39.	Нийслэлийн ерөнхий боловсролын 116 дугаар сургуультай ойр явган хүний гарцыг дуут дохиотой болгох асуудлыг судалж, шийдвэрлэх	XI-XII сард	НБГ 116-р сургууль	
40.	Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар сургуулийн гадна талбайн тохижилтын зураг төслийг хийлгэх, төсвийг судлан, шийдвэрлэх	X/30- XI/30	СХОГ БЕГ НБГ	29, 116-р сургууль
<b>Долоо. Тэгш хамруулах боловсролыг дэмжих мэргэжил арга зүйг түгээн дэлгэрүүлэх хүрээнд:</b>				
41.	Тэгш хамруулах чиглэлээр арга зүйгээ түгээн дэлгэрүүлэх, сургалт зохион байгуулах зардлыг тусгай сургууль, цэцэрлэгийн төсөвт тусгах /бичиг хэрэг, томилолт, унааны зардал/	жилдээ	СХОГ БЕГ НБГ	Сургуулиуд
42.	Ерөнхий боловсролын сургуулиуд, дэмжих төвийг мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	жилдээ	НБГ Сургуулиуд	ТББ
43.	Тэгш хамруулах боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, чадавжуулах сургалт зохион байгуулах, дотоодод болон гадаад улсад сургалтад хамруулах	жилдээ	БЕГ НБГ ГХХАГ	ТХСБХ
44.	Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулахын ач холбогдол, үр дүнг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	жилдээ	БЕГ НБГ	ТББ Сургуулиуд
45.	Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар сургуульд дэмжих төв ажиллуулах танхимын тохижилт, засварын ажлын тооцоолол гаргаж, танилцуулах, ТББ-тай хамтран ажиллах бэлтгэл хангах	XI/01-XI/30	БЕГ НБГ СХОГ	70-р сургууль ТББ
46.	Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төвийн үйлчилгээнд хамруулах бэлтгэл ажлыг хангах	XI-XII сард	БЕГ НБГ НТСТ	ТББ